



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/272

Чингис хот

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль болохтой холбогдуулан сумын сонгуулийн хорооны ажиллах байр, санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн байранд үнэ төлбөргүй байрлуулж аюулгүй байдлыг хангах, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Санал авах байрыг бэлтгэхэд шаардлагатай хэрэгслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Санал авах байрыг бэлтгэхэд
шаардлагатай хэрэгслийн жагсаалт

1. Төрийн далбаа
2. Сонгогч саналаа нууцаар өгөхөд зориулсан хоёроос доошгүй бүхээг
3. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг
4. Суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг
5. Сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц
6. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын крайль үсэг бүхий хавтас, томруулдаг шил
7. Саналын хуудаст саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар
8. Саналын хуудаст саналаа тэмдэглэх зориулалтын үзэг
9. Хэсгийн хорооны бүрэлдэхүүн болон мэдээллийн технологийн даамал, улсын бүртгэлийн итгэмжпэгдсэн ажилтан ажиллахад хүрэлцэхүйц тооны ширээ, сандал, утас, факс, компьютер, принтер
10. Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй хэсэгт, цахилгаан үүсгүүр
11. Ажиглагчдын ширээ сандал
12. Саналын хуудас хадгалах сэйф, лацны тэмдэг
13. Мэргэжлийн байгууллагын зөвлөмжид заасан халдвар хамгаалал, ариутгалын хэрэгслийг байрлуулж санал авах байрны зохион байгуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийх
14. Санал авах байр бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.
15. Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.
16. Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулах бөгөөд Хяналтын камерыг сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд саад учруулахгүйгээр байрлуулна.
17. Санал авах байрны гадаа Монгол Улсын Төрийн далбааг байрлуулж, ".....сонгуулийнтойргийн.....дугаар хэсгийн санал авах байр" гэсэн хаягтай байна.
18. Санал авах байранд санал тоолох төхөөрөмж, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл болон саналын хуудас хүлээн авснаас хойш тухайн санал авах байрыг Цагдаагийн хамгаалалтад авах.
19. Хууль тогтоомжид заасан бусад